

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Энэхүү тайлан нь байгаль орчин, нийгэм, засаглалын /БОНЗ/ чиглэлээр тайлант хугацаанд авч хэрэгжүүлсэн стратеги, арга хэмжээ, нөхцөл байдлыг хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид, олон нийтэд ил тод нээлттэй мэдээллэх зорилготой.

2015 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Тогтвортой Хөгжлийн дээд хэмжээний чуулга уулзалтаар 17 зорилго, 169 зорилт, 244 шалгуур үзүүлэлттэй "Тогтвортой хөгжлийн зорилго 2030" хөтөлбөрийг баталсан. Эдгээр үзүүлэлтүүдийг байгууллагын үйл ажиллагаанд нийцүүлж цаашдын зорилго болгон хэрэгжүүлснээр байгууллагын тогтвортой байдлыг улам бэхжүүлж, урт хугацааны үнэ цэнийг бий болгох юм. Улмаар БОНЗ-ын гүйцэтгэл өндөр байх тусам дотоод, гадаадын хөрөнгө оруулалтаас өндөр ашиг хүртэж, аливаа хямралыг эрсдэл багатай туулах чадвартай болно. Уг тайланд манай байгууллагын үйл ажиллагааны онцлогоос хамаарч нийт 5 хамрах хүрээнд 23 бүлэг, 108 үзүүлэлтүүдийг тусгав.

Огноо (он, сар, өдөр):	2025.01.27
Үнэт цаас гаргагчийн нэр:	Говь ХК
Үнэт цаасны нэр, код (МХБ симбол):	GOV
Салбарын ангилал:	Үйлдвэрлэл
Тайланд орсон компаниуд (энэхүү тайланд орсон толгой болон охин компаниудын мэдээлэл):	-
Тайлангийн хамрах хугацаа:	2024/01/01 - 2024/12/31
Хариуцсан албан тушаалтны овог нэр, албан тушаал, холбоо барих имэйл хаяг, утас:	О.Жаргалмаа, Тогтвортой хөгжлийн ахлах менежер jargalmaa.o@gobiashmere.com 99695070
Тайланг баталгаажуулсан гүйцэтгэх удирдлагын мэдээлэл (нэр, албан тушаал):	Б.Чингүүн, Нийцэл хариуцсан захирал
Гүйцэтгэх удирдлага эсвэл ТУЗ-ийн даргын гарын үсэг:	Б.Амарсайхан, Гүйцэтгэх захирал

Бүлэг	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Үзүүлэлт /2024 он/	
<b>1. Тогтвортой хөгжлийн удирдлагын системтэй холбоотой шалгуур үзүүлэлт</b>				
1. Тогтвортой хөгжлийн удирдлагын систем	1.1 Удирдлагын амлалт	Тийм/Үгүй	Тийм. ТУЗ-өөс 2022 онд "Тогтвортой хөгжлийн үүрэг амлалт"-ыг баталсан бөгөөд 2024 онд уг үүрэг амлалтын цар хүрээ агуулгаа шинэчлэн тодорхойлж, "Тогтвортой хөгжлийн стратегийн бодлого"-ыг шинээр баталсан. Тус бодлого нь бизнесийн үйл ажиллагааны шийдвэр гаргалт, стратеги төлөвлөлтийн явцад оролцогч бүхий л талуудыг Тогтвортой хөгжлийн бодлогод нэгтгэх, байгаль орчны менежмент, нийгмийн хариуцлага, ёс зүйтэй засаглалтай холбоотой эрсдэл, боломжуудыг удирдах зорилготой. <a href="https://info.gobi.mn/policy">https://info.gobi.mn/policy</a>	
	1.2 Тогтвортой хөгжлийн бодлого, зохицуулалт	Тийм/Үгүй	Тийм. <a href="https://info.gobi.mn/policy">https://info.gobi.mn/policy</a>	
	1.3 Бүтэц удирдлага	1.3.1 Тогтвортой хөгжлийн асуудал хариуцсан хороо байдаг эсэх	Тийм/Үгүй	Тийм. ТУЗ-ийн түвшинд Тогтвортой хөгжлийн хороо байхгүй ч Компанийн хэмжээнд Тогтвортой хөгжлийн хэлтэс байдаг. ТУЗ-өөс тогтвортой хөгжлийн асуудалд тогтмол анхаарал хандуулж, жилд 3 удаа ТУЗ-ийн ээлжит хурлаар Тогтвортой хөгжлийн хэлтсийн хэрэгжүүлж буй БОНЗ-ын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлантай танилцан хэлэлцэж, заавар чиглүүлгээр ханган ажиллаж байна. 2025 оноос ТУЗ-ийн дэргэд БОНЗ-ын хороог шинээр байгуулж, "Тогтвортой хөгжлийн стратегийн бодлого"-ын хэрэгжилтийг ханган ажиллахаар төлөвлөж байна.
		1.3.2 ТУЗ-ийн түвшинд тогтвортой хөгжил хариуцсан гишүүн байдаг эсэх	Тийм/Үгүй	Үгүй. Тогтвортой хөгжил хариуцсан ТУЗ-ийн гишүүн байхгүй бөгөөд компанийн хэмжээнд тогтвортой хөгжлийн үйл ажиллагаа жигдрэх хүртэл бүх гишүүд хамтран анхаарал хандуулж ажиллаж байна. ТУЗ-н хараат бус гишүүд 2024 оны 5, 6, 9-р саруудад Тогтвортой хөгжлийн олон улсын хууль тогтоомж, ТХ-ийн бодлого, Уур амьсгалын өөрчлөлт ба хүлэмжийн хий чиглэлээр сургалтад хамрагдаж, стратегийн бодлого батлав.
		1.3.3 Гүйцэтгэх удирдлагын түвшинд тогтвортой хөгжил хариуцсан албан тушаалтан байдаг эсэх	Тийм/Үгүй	Тийм. Тогтвортой хөгжлийн хэлтэс нь Нийцэл хариуцсан захирлын /Chief Compliance Officer/ удирдлагад компанийн тогтвортой хөгжлийн цаашдын бодлого, зорилтуудыг тодорхойлон хэрэгжүүлж гүйцэтгэлийн үр дүнг оролцогч болон сонирхогч талуудад тайлагнаж, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг сайжруулан ажиллаж байна.
		1.3.4 Үйл ажиллагааны түвшинд тогтвортой хөгжил хариуцсан хэлтэс, албан тушаалтан байдаг эсэх	Тийм/Үгүй	Тийм. "Тогтвортой хөгжлийн хэлтэс нь: Тогтвортой хөгжлийн удирдлага Удирдлагын тогтолцоо, Байгаль орчин, Химийн бодис, хог хаягдал, Эрчим хүч, усны менежментийн хүрээнд байгууллагын тогтвортой хөгжлийн богино-урт-дунд хугацааны бодлого, зорилтуудыг тодорхойлон тэдгээрийг хэрэгжүүлэх, хянах, тайлагнах зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна
		1.3.5 ТУЗ-ийн хурлын хөтөлбөрт тогтвортой хөгжлийн асуудлыг албан ёсоор тусгадаг уу?	Тийм/Үгүй	Тийм. ТУЗ-ийн жилийн төлөвлөгөөнд БОНЗ-ын үйл ажиллагааны талаар хэлэлцэх хуваарийг тусган, жилд 3 удаа ТУЗ-ийн ээлжит хурал дээр төлөвлөгөөний дагуу хэлэлцэн ажиллаж байна. Хурлын үр дүнг жилийн үйл ажиллагааны тайланд тусгадаг.
	1.4 Тогтвортой байдлын нөлөөллийн үнэлгээ	Тийм/Үгүй	Тийм. Говь ХК-ийн Байгаль орчны нөлөөллийг ялган тогтоох журмын дагуу бид үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг жил бүр үнэлэн, тэдгээрийг бууруулах арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэн ажилладаг. Цаашид БОНЗ-н хүрээнд дэх нөлөөллийг үнэлэх, тогтолцоог сайжруулан ажиллахаар төлөвлөж байна.	
	1.5 Чадавч бүрдүүлэлт	хүн/цаг	1 ажилтанд ногдох тогтвортой хөгжлийн сургалт: <b>0.65 хүн/цаг</b> Тогтвортой хөгжлийн чиглэлийн нийт 29 төрлийн дотоодын болон гадны сургалтад давхардсан тоогоор 1975 хүн нийтдээ 2977.5 цагийн сургалтанд хамрагдав.	
	1.6 Хяналт	Тийм/Үгүй	Үгүй. Тогтвортой хөгжлийн асуудал нь аудитын хорооны үйл ажиллагаа, дотоод хяналтын чиг үүрэгт хамаардаггүй	
1.7 Тогтвортой байдлын тайлагнал	Тийм/Үгүй	Тийм. Тогтвортой хөгжлийн үйл ажиллагааны тайланг улирал тутамд 1 удаа, жилийн үйл ажиллагааны тайланг 1 удаа олон нийт сонирхогч талууддаа тайлагнадаг бөгөөд ТУЗ-д жилд 3 удаа тайлагнадаг.		
1.8 БОНЗ-ын эрсдэлийн удирдлага	Тийм/Үгүй	Үгүй. Эрсдэлийн үнэлгээ дунд БОНЗ-н үзүүлэлтүүдийг авч үздэг боловч, тусад нь БОНЗ-н эрсдэлийн үнэлгээ хийдэггүй. 2025 онд БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээг байгууллагын эрсдэлийн менежменттэй хослуулан хэрэгжүүлэхээр ажиллана.		
		Тийм. 1. Бид тайлант онд Тогтвортой хөгжлийн зөвлөх үйлчилгээний хүрээнд хэд хэдэн дотоодын болон олон улсын зөвлөх үйлчилгээний байгууллагуудтай /PWC, SBC, RCS/ хамтран байгууллагын ТУЗ, гүйцэтгэх удирдлагууд болон дунд шатны удирдлага ажилтнуудад сургалт, чиглүүлэг авч хамтран ажилласан. Мөн бусад байгууллагын хүсэлтээр тогтвортой хөгжлийн чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлын хүрээнд туршлага солилцох яриа хэлэлцүүлэгт оролцсон.		

1.9 Гишүүнчлэл, хамтын ажиллагаа	1.8.1 Тогтвортой хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын болон дотоодын холбоо, нэгдэлтэй нэгдэж хамтран ажилладаг уу?	Тийм/Үгүй	<p>2. Тогтвортой Ноос Ноолуурын Эвсэл /Sustainable Fibre Alliance/-ын гишүүн байгууллага юм.</p> <p>3. НҮБХХ-с хэрэгжүүлдэг "Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь (АДАПТ)" төсөлтэй хамтран малчдын бүлэгт түүхий эдийн бэлтгэл, малын тавлаг байдал, чанарын шаардлагын чиглэлээр сургалт оров.</p> <p>4. Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам /ХХААХҮЯ/, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам /БОУАӨЯ/, Тогтвортой ноос, ноолуурын эвсэл /ТННЭ/-с хамтран зохион байгуулсан "Сорилтыг давж хүлээлтэд нийцэх Байгалийн ширхэгт" чуулганд оролцож, ноолуурын үйлдвэрлэлд эмэгтэйчүүдийн оролцооны тэгш байдал, өрхийн амьжиргаанд болон ашиг тус хүртэхэд оруулж буй хувь нэмрийг хүндэтгэн үнэлдэг "Шилдэг малчин эмэгтэй" шагналын ивээн тэтгэж хамтран ажиллав.</p> <p>5. Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрт шилжих боломжийг судлан, Монгол - Япон улсын Хамтарсан Кредит Олгох Механизм /JCM/ төслийн талаар Япон улсын Саппоро хотын захирагч болон холбогдох төслийн багтай уулзалт хийн, нарны эрчим хүчний шийдлийн судалгаа хийв.</p> <p>6. Хятадын ХАА-н ОУ-ын хамтын ажиллагааг дэмжих CAPIAC байгууллагаас Хятад улсын Бээжин хотноо зохион байгуулсан "Global Sustainable Natural Fibers" хуралд оролцов.</p> <p>7. Азийн Хөгжлийн Банктай хамтран "Уур амьсгалын өөрчлөлтөд малчдыг бүлгэмээр дасан зохицуулах, бэлчээрийн тогтвортой менежментийг бий болгох туршилтын төсөл"-ийг хэрэгжүүлэхээр хамтын ажиллагааг эхлүүлэв.</p> <p>8. Бүгд Найрамдах Хятад Улсад Азийн Хөгжлийн Төвөөс зохион байгуулсан "Workshop on Green Business Models"-д Говь ХК-аас амжилттай оролцож Тогтвортой ногоон бизнесийн моделийг хэрхэн нэвтрүүлэх талаар суралцлаа.</p>
----------------------------------	---	-----------	---

**2. Байгаль орчны шалгуур үзүүлэлтүүд**

2. Эрчим хүч	2.1 Нийт эрчим хүчний хэрэглээ	2.1.1 Эрчим хүчний нийт зарцуулалтын хэмжээ болон зардал (жилээр)	кВт.ц	2024 онд зарцуулсан нийт эрчим хүчний хэрэглээ: Цахилгаанд шилжүүлж тооцвол: <b>32,635,576 кВт.ц</b> Дулаанд шилжүүлж тооцвол: 117,487 ГДж Нийт эрчим хүчний зардал: 3,356,330,733 ₮
	2.2 Цахилгаан	2.2.1 Цахилгааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	кВт.ц	Нийт зарцуулсан ЦЭХ: <b>8,929,883 кВт.ц</b> Өмнө оноос 1,200,742 кВт.ц-г бага хэрэглэсэн буюу 11.85%-г хэмнэсэн.
	2.3 Дулаан	2.3.1 Дулааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	ГДж	Нийт зарцуулсан ДЭХ: <b>23,216 ГДж</b> Өмнө оноос 84 ГДж-г бага хэрэглэсэн буюу 0.36%-г хэмнэсэн.
	2.4 Уур	2.4.1 Уурны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	ГДж	Нийт уурын хэрэглээ: <b>59,116 ГДж</b> Өмнө оноос 356 ГДж-г бага хэрэглэсэн буюу 0.6%-г хэмнэсэн.
	2.5 Хүрэн эрчим хүч	2.5.1 СЭХ-ээс бусад эрчим хүчний хэрэглээний хувь (жилээр)	%	Хүрэн эрчим хүч буюу шатахууны хэрэглээний эзлэх хувь: <b>0.024%</b>  Нийт зарцуулсан шатахууны хэмжээ: 82,500 л Шатахууны зардал: 197,245,728 ₮ Эрчим хүчний нэгжид шилжүүлбэл: 2,882 ГДж  Эрчим хүчний хэрэглээ нь төвийн бүсийн нэгдсэн ЭХС-с хангагддаг бөгөөд өөр эрчим хүчний үүсгүүр ашигладаггүй болно. Түлш, шатахууны эх үүсвэр нь нүүрс, газрын тос, байгалийн хий зэргээс гарган авдаг тул хүрэн эрчим хүчний төрөлд тооцож холбогдох мэдээллийг оруулав.
	2.6 Сэргээгдэх эрчим хүч	2.6.1 СЭХ-ний хэрэглээний хувь (жилээр)	%	Нийт сэргээгдэх эрчим хүчний хэрэглээний эзлэх хувь: <b>0.16%</b>  Байгууллагын гадна талбайн гэрэлтүүлэг нь нарны зайн гэрэлтүүлэг бөгөөд жилд 51,800 кВт.ц-н эрчим хүчийг зарцуулдаг.

3. Хүлэмжийн хийн ялгарал	3.1 Хүлэмжийн хийн ялгаруулалт	3.1.1 Байгууллагын шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан нийт хүлэмжийн хийн дүн (сар, жилээр)	CO2/тонн	2024 онд Нийт: <b>9,848 тонн CO2</b> eqv.-г ялгаруулсан. Score 1: 876 тонн CO2 eqv. Score 2: 8,717 тонн CO2 Score 3: 255 тонн CO2 eqv.
	3.2 Бууруулсан хүлэмжийн хий	3.2.1 Байгууллагын шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан хүлэмжийн хийн хэмжээ (сар, жилээр)	CO2/тонн	Бууруулсан хүлэмжийн хий: <b>908 тонн CO2</b>  Манай байгууллагын хүлэмжийн хийн ялгарлын 88.5%-ийг Score 2 буюу эрчим хүчний хэрэглээнээс үүдэлтэй ялгаруулалт эзэлдэг бөгөөд эрчим хүчний хэмнэлтийг бий болгох арга хэмжээ болон хог хаягдлын менежментийг сайжруулснаар хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулав.
	3.3 Дүйцүүлэх арга хэмжээ /Карбон офсет/	3.3.1 Нийт карбон офсет буюу дүйцүүлэх арга хэмжээний (мод тарих хөтөлбөр, эсвэл хүлэмжийн хийг бууруулах гадны төслийг дэмжих гэх мэт) бууралт	CO2/тонн	Нийт дүйцүүлэн хамгаалах арга хэмжээнээс бууруулсан хүлэмжийн хий: <b>42,1 тонн CO2</b> Говь ХК 2024 онд 1300 ширхэг шинэс, улиас мод, 125 ширхэг нарс, гацуур мод, 1200 м <sup>2</sup> талбайд зүлэжүүлэлт, 3000 ширхэг мандалын цэцэг тарих үйл ажиллагаа нь жилд нийтдээ ойролцоогоор 30,228 кг (30 тонн) хүлэмжийн хий CO <sub>2</sub> eqv. шингээж бууруулсан. Мөн 2023 онд тарьсан 3000 ширхэг хайлаас, 200 ширхэг улиас мод нь энэ жил нийт 11,872 кг (12 тонн) CO2 eqv. хүлэмжийн хий шингээсэн байна.

4. Уур амьсгалын өөрчлөлт	4.1 Уур амьсгалын бодлого, журам	4.1.1 Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тусдаа эсвэл бусад журамд тусгасан бодлоготой юу?	Тийм/Үгүй	<b>Тийм.</b> 2024 оны 11-р сард ТУЗ-н тушаалаар "Говь ХК-ийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах бодлого"-г баталсан. Энэхүү бодлогын зорилго нь үйл ажиллагаанаас ялгарах хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, Net zero-д тэмүүлэх, уур амьсгалын өөрчлөлийг сааруулах болон дасан зохицоход чиглэсэн болно. <a href="https://info.gobi.mn/policy">https://info.gobi.mn/policy</a>
	4.2 Уур амьсгалын эрсдэл ба боломжийн үнэлгээ	4.2.1 Уур амьсгалын эрсдэл, боломжийн талаарх үнэлгээ хийсэн үү?	Тийм/Үгүй	<b>Тийм.</b> Компани нь байгалийн гамшгийн эрсдэл тэр дундаа гал, үер, зудын эрсдэлийг тодорхойлон хагас жил тутам эрсдэлийн үнэлгээг хийж, хариу арга хэмжээний төлөвлөлтийн дагуу мониторингийг гүйцэтгэн тайлагнадаг ба 2024 оны 2-р хагас жилийн эрсдэлийн мониторингоор 2 буюу БАГА түвшинд байна. цаашид уур амьсгалын эрсдэлийг илүү боловсронгуй болгохоор ажиллана.
	4.3 Эдийн засгийн хохирол	4.3.1 Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг, үйл явдлын улмаас учирсан эдийн засгийн нийт хохирлын хэмжээ	Төгрөг	Байхгүй.
	4.4 Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хөрөнгө оруулалт	4.4.1 Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дэд бүтэц, дасан зохицол, бүтээгдэхүүн хөгжилд оруулсан нийт хөрөнгө оруулалтын дүн	Төгрөг	2024 оны нийт хөрөнгө оруулалт: <b>2,500,593,802 ₮</b> Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, эрчим хүч хэмнэлтийн төлөвлөгөөний дагуу тайлант онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний дүн. Эдгээрээс дурьдвал: - Хүлэмжийн хийн ялгарлыг тооцох; - Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ; - Эрчим хүчний дэлгэрэнгүй аудит; - Бохир ус цэвэрлэх байгууламжийн төсөл эхлүүлэх; - Эрчим хүчний хэмнэлттэй гэрэлтүүлэг; - Хог хаягдлын менежмент;
	4.5 Уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх эсвэл дасан зохицох	4.5.1 Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор компанийн ашигт ажиллагаа эсвэл бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт нөлөөлөх эрсдлээс урьдчилан сэргийлэх, (хэрэв урьдчилан сэргийлэх боломжгүй бол) дасан зохицох чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээ/алхмуудыг тодорхойлсон уу?	Тийм/Үгүй	<b>Тийм.</b> Бид уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх, дасан зохицоход чиглэсэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. * Байгалийн нөөц ус, эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээг нэмэгдүүлэх, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох; * ОЕКО-ТЕХ эко гэрчилгээтэй бүтээгдэхүүн хөгжүүлэх * Гамшгийн үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж бэлэн байдлыг хангах; * Малчдад уур амьсгалын өөрчлөлтийн талаар мэдлэг олгох, чанартай, цөөн тооны мал аж ахуйг сурталчлах; * 2024 онд уур амьсгалын өөрчлөлтөд малчдыг бүлгэмээр дасан зохицуулах, бэлчээрийн тогтвортой менежментийг бий болгох туршилтыг төслийг 2029 он хүртэл Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хамтран хэрэгжүүлэхээр гэрээ байгуулан төслийн бэлтгэл ажлыг ханган ажиллав.

5. Ус	5.1 Усны хэрэглээ	5.1.1 Ашигласан усны нийт хэмжээ болон зардал (сар, жилээр)	м3	2024 онд нийт <b>103,112 м3</b> ус хэрэглэсэн ба усны төлбөрт 615,201,820 ₮ төлөв. /Сард дунджаар 8,593 м3/
	5.2 Хэмнэсэн ус	5.2.1 Хэмнэлт, үр ашгийг дээшлүүлснээр нийт хэмнэсэн усны хэмжээ (сар, жилээр)	м3	Тайлант оны нийт цэвэр усны зарцуулалт нь өмнө онтой харьцуулбал 38,703 м3 бага ус зарцуулав.
	5.3 Дахин боловсруулсан ус	5.3.1 Дахин ашигласан, боловсруулсан усны эзлэх хувь (сар, жилээр)	%	Дахин боловсруулсан ус байхгүй.
	5.4 Хаягдал бохир ус цэвэрлэх	5.4.1 Цэвэрлэсэн нийт хаягдал бохир усны хэмжээ	м3/л	<b>33.65 мянган м3</b> технологийн хаягдал усыг үйлдвэрийн бохир ус цэвэрлэх урьдчилсан цэвэрлэх байгууламжаар дамжуулан MNS 6561 стандартад нийцүүлэн цэвэрлэж, төвийн шугамд нийлүүлэв.
	5.5 Аюулгүй баталгаат ундны ус	5.5.1 Компанийн ажилчид ундны цэвэр усаар хангагдсан байдал	Тийм/Үгүй	<b>Тийм.</b> Ундны усны шинжилгээг MNS 9000:2018 стандартад нийцүүлэн нийт 69 цэгт шинжилгээ хийлгэсэн бөгөөд шинжилгээний үр дүн нийт 95.6% нь унд эрүүл ахуйн усны стандартад нийцсэн цэвэр аюулгүй, нянгийн бохирдолгүй байсан.
	5.6 Эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламж	5.6.1 Компанийн ариун цэврийн орчны үйлчилгээний стандарт байгаа юу?	Тийм/Үгүй	<b>Тийм.</b> Ариун цэврийн өрөө болон усанд орох газруудыг нийт ажилтнуудад хүрэлцээтэй байхаар буюу ариун цэврийн өрөө нь 30 эмэгтэй тутамд султуур, 40 эрэгтэй тутамд 1 султуур байхаар байршуулж, эрүүл ахуйн шаардлагыг ханган ажиллаж байна.
6. Хатуу хог хаягдал	6.1 Хог хаягдал	6.1.1 Нийт ялгаруулсан хог хаягдлын хэмжээ (сар, жилээр)	тонн	Нийт байгууллагын хэмжээнд үүссэн хог хаягдлын хэмжээ: <b>178.84 тонн</b> . Үүнээс: - Энгийн хог хаягдал 33.57 тонн - Технологийн хаягдал 140.07 тонн - Аюултай хаягдал 5.29 тонн тус тус үүссэн байна.  Энгийн хог хаягдлыг эх үүсвэрээр нь дахивар, цаас, гялгар, бусад гэж ангилдаг ба ялгах хогийн савыг нийт үйлдвэр, оффисын хэмжээнд дотор талбайд 48 байршилд 270 ширхэг, гадна талбайд 4 байршилд 16 ширхэг тус тус байршуулсан. "Эко орчин" ХХК-тай хог тээвэрлэлтийн гэрээ байгуулан 2018 оноос эхлэн хамтран ажиллаж байна.
	6.2 Дахин боловсруулсан хатуу хог хаягдал	6.2.1 Хог хаягдлыг дахин боловсруулсан хувь (сар, жилээр)	%	Дахин боловсруулах үйлдвэрт шилжүүлсэн хог хаягдлын эзлэх хувь: <b>41.4%</b>  2024 онд нийт 128 удаагийн рейсээр цаасан хаягдал, гялгар уут, хуванцар савыг гэрээт компаниудад шилжүүлэн 13.91 тн хог хаягдлыг байгальд хаягдахаас сэргийлэв.
	6.3 Хортой хог хаягдал	6.3.1 Хортой хог хаягдлын нийт хэмжээ сар, жилээр (Үүнд цахилгаан хэрэгслийн хог орно.)	тонн	Нийт аюултай хог хаягдлын хэмжээ: <b>5.29 тонн</b>  Аюултай хог хаягдлыг БОУАӨЯ-ны тусгай зөвшөөрөл бүхий байгууллагатай хамтран ажиллах гэрээний хүрээнд 1.58 тонн химийн бодисын сав, 0.18 тонн баттерей, 3.24 тонн цахим хаягдал, 0.24 тонн техникийн тосны хаягдлыг тус бүр байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэн мэргэжлийн байгууллагад шилжүүлж устгуулсан. 1528 ширхэг химийн бодисын савыг химийн бодис нийлүүлэгч гэрээт байгууллагад буцаасан.
7. Биологийн олон янз байдал	7.1 Ногоон байгууламж, төлөвлөлт	7.1.1 Байгаль орчны хувьд тогтвортой ашиглаж буй нийтийн эзэмшлийн талбай буюу барьсан ногоон байгууламжийн талбайн нийт талбайд эзлэх хувь	%	Байгууллагын гадаа талбайд нөхөн тарилт хэлбэржүүлэлтийн ажлууд хийгдэж нийт 49883м2 талбайн <b>13.1%</b> -ийг ногоон байгууламжийн талбай эзэлж байна.
	7.2 Зэрлэг ургамал, амьтдыг хамгаалах	7.2.1 Хамгаалсан төрөл зүйлийн тоо	Тоо	Байхгүй.
<b>3. Нийгмийн шалгуур үзүүлэлтүүд</b>				
8. Хүний нөөц	8.1 Хүний нөөцийн бодлого	8.1.1 Хүний нөөцийн бодлого, журам бий юу?	Тийм/Үгүй	<b>Тийм.</b> Хүний нөөцийн хариуцлагатай менежментийг бий болгох, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, түүнд тохирсон шударга, цалин урамшуулал олгоход чиглэсэн бодлого баримтлан ажилладаг. Мөн хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой 19 төрлийн журам хэрэгжиж байна.
		8.1.2 Нийт ажилтны тоо, насны ангилал, байршил	Тоо	Нийт 1652 ажилтантай. Үүнээс:  Насны ангилал: * Z- 67 /4%/ * Y- 934 /57%/ * X- 595 /36%/ * BB- 56 /3%/  Байршил: /99%/ * УБ хот 1615 * Дархан 3 * Хэнтий 34  Олон улс 13 /1%/ * USA 1 * Европ 12
	8.2 Хүний нөөцийн тогтвортой байдал	8.2.1 Үндсэн ажилтнуудын ажлын байрны сэлгээний хувь (тухайн онд ажлаасаа гарсан ажилтнуудын тоог ажилласан ажилтнуудын дундаж тоонд хуваах)	%	2024 онд хүний нөөцийн эргэц 47.9% байна.
	8.3 Шинээр бий болгосон ажлын байр	8.3.1 Өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн бүтэн цагийн ажлын байрны тоо	Тоо	Шинээр бий болсон ажлын байрны тоо: <b>7</b>
	8.4 Сургалт	8.4.1 Нэг ажилтанд ногдох жилийн дундаж сургалтын цаг	хүн/цаг	Нэг ажилтанд ногдох сургалтын цаг: <b>1.34 хүн/цаг</b>  2024 онд нийтдээ 278 сургалт зохион байгуулагдаж, сургалтад 2,134 ажилтан давхардсан тоогоор хамрагдсан бөгөөд сургалтад зарцуулсан нийт төсөв: 190,844,640 ₮
	8.5 Нийгмийн халамжийн бодлого	8.5.1 Бүтэн болон хагас цагийн ажилтанд зориулсан нийгмийн халамжийн бодлого байдаг эсэх	Тийм/Үгүй	Нийгмийн халамжид чиглэсэн дараах ажлуудыг хэрэгжүүлж байна. Үүнд: * Хүүхэд хамгааллын бодлогын дагуу ажлын цагийн уян хатан зохицуулалт; * ХБИ ажилтнуудыг гэрээс нь ажиллуулах зохицуулалт; * Ажилтнуудын 2-5 насны 120 хүүхдэд сургуулийн өмнөх боловсролыг үнэ төлбөргүй олгох Говийн багачууд цэцэрлэг; * Хуулийн дагуу нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогчоос цаг хугацаандаа төлөх; * Хуулийн дагуу өндөр насны тэтгэвэрт гарч буй ажилтнууддаа ажилласан жилээс хамаарсан тэтгэмж; * Дотоод журмын дагуу ажилтнуудад зориулсан буцалтгүй тусламж, хөнгөлөлт хангамжууд; * Хөдөө орон нутгийн ажилтнуудад амьдрах дотуур байр;
8.6 Тэтгэмж	8.6.1 Бүтэн болон хагас цагийн ажилтанд зориулсан тэтгэмж, урамшуулал байдаг эсэх	Тийм/Үгүй	<b>Тийм.</b> Дараах тэтгэмж, урамшууллыг олгож байна. * Хуулийн дагуу өндөр насны тэтгэвэрт гарч буй ажилтнууддаа ажилласан жилээс хамаарсан тэтгэмж; * Дотоод журмын дагуу ажилтнуудад зориулсан буцалтгүй тусламж, хөнгөлөлт хангамжууд; * Ажилтнуудад зориулсан үнэ төлбөргүй автобус/автомашин үйлчилгээ; * Ажилтнуудад зориулсан үнэ төлбөргүй хоол; * Компанийн ашгаас хамаарсан урамшуулал;	
9.1 ХАБЭА-н бодлого	9.1.1 ХАБЭА-н бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэгсэн)?	Тийм/Үгүй	<b>Тийм.</b> 2024 оны 5-р сарын 2-ны өдрийн Гүйцэтгэх захирлын А/185 тоот тушаалаар Нэгдсэн Удирдлагын Тогтолцооны хүрээнд Чанар, Хөдөлмөрийн Эрүүл Мэнд Аюулгүй байдал болон Байгаль орчны бодлогыг боловсруулан баталсан. Мөн ХЭМАБ-н үйл ажиллагааг зохицуулах 18 журам байдаг бөгөөд бодлого, журмын хэрэгжилтийг хангуулан, тасралтгүй сайжруулан ажиллаж байна.	
9.2 Аюултай тохиолдол	9.2.1 Үйлдвэрийн осол	тоо	Говь ХК-ийн хэмжээнд 2024 онд хугацаа алдсан гэмтэл буюу <b>үйлдвэрлэлийн осол бүртгэгдээгүй</b> . 1. 2024 онд дунджаар 1617 ажилтан 2. Хугацаа алдсан гэмтэлгүй ажилласан өдөр-264, 3. Хугацаа алдсан гэмтэлгүй ажилласан цаг-4,569,768 хүн/цаг,	
	9.2.2 Хугацаа алдсан гэмтлийн давтамж	тоо	Хугацаа алдсан гэмтлийн давтамж- <b>0.00</b>	
9.3 ХАБЭА-н сургалт	9.3.1 Жилд нэг ажилтанд ногдох дундаж ХАБЭА сургалтын цаг	хүн/цаг	Жилд нэг ажилтанд <b>4.1 хүн/цагийн</b> сургалт, зааварчилгаа хийгдсэн.	

9. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)

		9.4.1 Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан ажилтнуудын тоо, жилээр	хүн	Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан ажилтны тоо /Давхардсан тоогоор/ - <b>13,474 хүн</b> * Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх нэгжээр 3500 ажилтан өдөр тутмын үзлэг үйлчилгээ авсан. *2024 оны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх хугацаат үзлэгт хэвийн бус нөхцөлд ажилладаг 199 ажилтан, хэвийн нөхцөлд ажилладаг 573 ажилтан хамрагдсан. *Шинэ ажилтны үзлэгт 750 ажилтан хамрагдсан. Үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтран сувилгаа, эмчилгээ шаардлагатай ажилтны оношилгоо, эмчилгээний асуудалд хяналт тавьж эмийн болон эмийн бус эмчилгээнд хамруулан эрүүлжүүлэн чийрэгжүүлэх арга хэмжээ авч нийт 60 хүн хамруулсан. *Сувилгахуйн 14 төрлийн тусламж үйлчилгээг давхардсан тоогоор 8392 удаа үзүүлсэн.
9.4 Эрүүл мэндийн хөтөлбөр		9.4.2 Ажилтнуудын эрүүл мэндийн судалгаа, сургалтын хөтөлбөр байдаг эсэх	Тийм/Үгүй	<b>Тийм.</b> Үзлэг хийлгэсэн ажилтнуудын бүртгэлийг цахим байдлаар тогтмол бүртгэдэг бөгөөд эрүүл мэндийн хугацаат үзлэгт орсон ажилтнуудын мэдээллийг архивлан шаардлагатай ажилтнууд дээр дата мэдээлэл үүсгэн тогтмол хянадаг. ХЭМАБ-н хэлтсийн нийт сургалтын төлөвлөгөөг нэгдсэн байдлаар гаргаж, батлуулдаг бөгөөд мэргэжлийн байгууллагаас зохион байгуулагдах сургалтын хөтөлбөрийг тухайн байгууллагаас боловсруулж, түүний дагуу сургалтыг зохион байгуулдаг.
		9.4.3 Заавал хийлгэх ёстой вакцинд хамрагдсан нийт ажилтан	Тоо	Анхан шатны үйлдвэрийн ажилчид болон ноолуур татан авах үед ажиллаж буй ажилчдад хачигт халдвараас урьдчилан сэргийлэх вакцинд <b>40 ажилтныг</b> давхардсан тоогоор <b>65 тун вакцинд хамруулсан.</b>
		9.4.4 Олон улсын хөдөлмөрийн эрүүл мэндийг хэрэгжүүлсэн байдал болон эрүүл мэндийн яаралтай тусламж үзүүлэх бэлэн байдал	Тийм/Үгүй	<b>Тийм.</b> Бид нийгмийн хариуцлага болон Health at Gobi төслийн хүрээнд "Цус сэлбэлт судлалын үндэсний төв"-тэй хамтран "ЦУСНЫ ДОНОРЫН ӨДӨРЛӨГ"-ийг 31 дэх жилдээ амжилттай зохион байгуулан 67 ажилтан 201 хүнд амьдрал бэлэглэсэн. Байгууллага өөрийн байрандаа Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх нэгжтэй. Шаардлагатай тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслээр бүрэн хангагдсан. Мөн газар, үйлдвэр, нэгж бүрт "Анхан шатны тусламж" үзүүлэх ажилчдыг томилж, жил бүр мэргэжлийн байгууллагаар чадавхжуулан "Сертификат" олгогддог.
9.5 Согтууруулах ундаа, тамхины хэрэглээ		9.5.1 Согтууруулах ундаа, тамхины хэрэглээний эсрэг байгууллагын дотоод журам байдаг эсэх	Тийм/Үгүй	Архи, согтууруулах ундаа хориглох журмын боловсруулалтын ажил хийгдэж байгаа бөгөөд журмын боловсруулалт 75%-н гүйцэтгэлтэй байна. 2025.03.15-нд эцсийн байдлаар батлуулахаар төлөвлөн ажиллаж байна.
10. Эрх тэгш байдал		10.1 Жендерийн бодлого, журам	Тийм/Үгүй	<b>Тийм.</b> Ажлын байрны дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамт, жендерийн тэгш эрх, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх журмыг 2022.03 сараас эхлэн баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Мөн 2024 оны 11-р сард ТУЗ-с "Хүний эрх, жендерийн бодлого"-г батласан бөгөөд цаашид үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллана.
		10.2 Ажлын байрны бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам	Тийм/Үгүй	<b>Тийм.</b> Ажлын байрны дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамт, жендерийн тэгш эрх, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх журмыг 2022.03 сараас эхлэн баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Мөн 2024 оны 11-р сард ТУЗ-с "Хүний эрх, жендерийн бодлого"-г батласан бөгөөд цаашид үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллана.
		10.3 Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам	Тийм/Үгүй	<b>Тийм.</b> Ажлын байрны дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамт, жендерийн тэгш эрх, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх журмыг 2022.03 сараас эхлэн баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Мөн 2024 оны 11-р сард ТУЗ-с "Хүний эрх, жендерийн бодлого"-г батласан бөгөөд цаашид үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллана.
		10.4 Ажилтнуудын хүйсийн харьцаа	%	Нийт үндсэн ажилтнуудын хүйс: * Эмэгтэй 1140 /69%/ * Эрэгтэй 512 /31%/
		10.5 Төлөөлөн удирдах зөвлөлийн хүйсийн харьцаа	%	ТУЗ-н нийт 9 гишүүнтэй. * Эмэгтэй 4 /44%/ * Эрэгтэй 5 /56%/
		10.6 Гүйцэтгэх удирдлагын хүйсийн харьцаа	%	Нийт 14 гүйцэтгэх удирдлагын түвшний ажилтан: * Эмэгтэй 8 /57%/ * Эрэгтэй 6 /49%/
		10.7 Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын хүйсийн харьцаа	%	"Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнууд: * Эмэгтэй 1140 /70%/ * Эрэгтэй 489 /30%/"
		10.8 Жендэрт суурилсан цалингийн зөрүү	харьцаа	Хүйсийн харьцаанаас хамаарсан цалингийн ялгаа байхгүй ажлын гүйцэтгэл, бүтээмжээс хамааран цалинждаг бөгөөд: * Эмэгтэй 2,300,000 төг * Эрэгтэй 2,400,000 төг дундаж цалингийн гүйцэтгэлтэй байна.
11. Хүртээмжтэй байдал		11.1 Хөгжлийн бэрхшээлтэй ажилтан бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм/Үгүй	<b>Тийм.</b> Говь ХК-ийн Нийгмийн хариуцлагын бодлогод ажилтнуудын тав тухтай байдлыг хангахад чиглэсэн дараах агуулга тусгагдсан байдаг. 3.4.1 Бүх ажилтнуудад аюулгүй ажиллах нөхцөл, нийцэмжит цалин хөлс, мэргэжлийн өсөлтийг хангах боломжийг олгох арга хэмжээ; 3.4.2 Жендерийн эрх тэгш байдлыг дэмжиж, эмзэг бүлэг болон нийгмийн цөөнхөд хамаарах иргэдэд шударга, эрх тэгш, үл ялгаварлах, хүртээмжтэй, хүсэмжит ажлын байр бий болгох арга хэмжээ;
		11.2 Хөгжлийн бэрхшээлтэй ажилтан нийт ажилтны тоонд эзлэх хувь	%	Хөгжлийн бэрхшээлтэй нийт 56 ажилтан ажиллаж байна. Энэ нь нийт ажилтны <b>1%</b> -ийг эзэлдэг.
		11.3 Орчны хүртээмж	Тийм/Үгүй	<b>Тийм.</b> Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудыг ажлын байр луу орж гарахад саадгүй зорчих гарц болон ариун цэврийн өрөөг ХБИ ажилтан ашиглах боломжтой байдлаар тохижуулсан.
		12.1 Оролцогч талуудын оролцооны засаглал	Тийм/Үгүй	<b>Тийм.</b> Говь ХК-ийн "Засаглалын бодлого"-д оролцогч талуудын эрх ашгийг ханган ажиллах тухай зорилтуудыг тодорхойлон оруулсан байдаг. Мөн ТУЗ-өөс 2023 оны 4-р сард "Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр", 11-р сард "Оролцогч талуудын хамтын ажиллагааны удирдлагын төлөвлөгөө"-г тус тус баталсан.
		12.2 Нийгмийн нөлөөллийн үнэлгээний бодлого журам	Тийм/Үгүй	<b>Тийм.</b> Бид 2024 оны 01-р сард Говь ХК-ийн "Нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдлын нөлөөллийг үнэлэх журам"-ын баталж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.
		12.3 Санал гомдлыг шийдвэрлэх бодлого / журам	Тийм/Үгүй	<b>Тийм.</b> 1. Ес зүйтэй холбоотой зөрчил маргааныг "Ес зүйн код"-ын зарчмаар "Шүгэл үлээх систем"-ээр хүлээн авч шийдвэрлэн ажиллаж байна. <a href="https://info.gobi.mn/whistleblowing/">https://info.gobi.mn/whistleblowing/</a> 2. Компанийн гүйцэтгэх захирлын 2022.11.03-ны өдрийн А/473 дугаар тушаалаар батлагдсан Говь ХК-ийн Ж-3АА-28-03 дугаартай "Оролцогч талуудын өргөдөл, санал, гомдол хүлээн авах, шийдвэрлэх журам"-ыг баримтлан сар, хагас, бүтэн жилээр тайлан мэдээ гаргаж холбогдох албан тушаалтнуудад танилцуулан дүгнэж ажилладаг

12. Нийгмийн хариуцлага ба ил тод байдал	12.4 Олон нийтэд ил тод мэдээлэх	12.4.1 Компанийн үйл ажиллагаа нөлөөлж буй иргэдэд мэдээлэл өгөх, санал хүсэлт авч, гомдол шийдвэрлэх тогтолцоо бий юу?	Тийм/Үгүй	<p><b>Тийм.</b></p> <p>1. Ажилчид шүгэл үлээх системд хандаж гомдол мэдээллээ өгч, шийдвэрлүүлэх боломжтой /https://info.gobi.mn/whistleblowing/ системийг ашигладаг. Мөн дараах сувгуудаар санал, гомдол хүлээн авч байна.</p> <p>Оролцогч талуудын санал, гомдлыг дараах сувгуудаар хүлээн авна. Үүнд:  *Дотоод хэрэглэгчийн санал, гомдлыг и-мэйл хаягаар /Complaint@gobi.mn/;  *Гадаад борлуулалтын газрын Европ зах зээлд ирсэн санал, гомдлыг support-1@gobicashmere.com и-мэйл хаяг, +49 3379 3418932 дугаараар,  Английн зах зээлийг support-4@gobicashmere.com и-мэйл хаяг, +44 7481 340102 дугаараар,  Америкийн зах зээлийг support-2@gobicashmere.com и-мэйл хаяг, +1 424 305 4009 дугаараар,  Хятадын зах зээлийг https://fuwu.taobao.com/ сайтаар, Утсаар 70139977; 70048888[G31] ;[G2] [G3] [G4]  *Компанийн албан ёсны цахим хуудсаар /info@gobi.mn/;  *Албан бичгээр хаяглагдан ирэхэд;  *Тухайн хариуцсан газрын холбогдох менежер, хэлтсийн дарга, газрын захирлаар дамжин ирэхэд;  *Шүгэл үлээх системээр;</p>
	12.5 Ажилчид/олон нийтийн санал гомдол	12.5.1 Ажилчид болон олон нийтээс ирсэн санал гомдлыг шийдвэрлэсэн хувь	%	<p>2024 онд компанийн хэмжээнд нийт 1252 санал, гомдол бүртгэгдсэнээс 1188 гомдол, 64 санал байв.</p> <p>Эдгээрээс бүтээгдэхүүнтэй холбоотой санал, гомдол-687, Үйлчилгээтэй холбоотой санал, гомдол-390,  Маркетингтай холбоотой санал, гомдол-102,  Вэбсайттай холбоотой санал, гомдол- 41,  Хувьцаа эзэмшигчтэй холбоотой санал, гомдол-16,  Ложистикийн үйл ажиллагаатай холбоотой гомдол-10, Санхүү, гааль татвартай холбоотой гомдол-4,  агуулахтай холбоотой-2 тус тус ирсэн бөгөөд <b>шийдвэрлэлт 100%</b> байна.</p>
	12.6 Нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалт	12.6.1 Нийгмийн хариуцлагын арга хэмжээ, хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө оруулалтын нийт орлогод эзлэх хувь	%	<p>Говь ХК-иас нийгмийн хариуцлагын хүрээнд нийт 2.24 тэрбум төгрөгийг зарцуулсан бөгөөд энэ нь нийт борлуулалтын орлогын <b>0.9%</b>-ийг эзэлж байна. НХ-н төсөл хөтөлбөрүүдээс дурдвал:</p> <p>1. Малчдын амьжиргааг дэмжих, тогтвортой түүхий эд бэлтгэхэд чиглэсэн "Тоогеортой ноолуур, Гурван талт хамтарсан төсөл"-ийг 2020 оноос эхлэн 4 дэх жилдээ хэрэгжүүлж байна. Тус төслийн хүрээнд энэ онд 135.5 сая төгрөг зарцуулсан;  2. Ажилтнуудын бие, сэтгэл зүй болон санхүүгийн эрүүл мэндийг дэмжих Health at Gobi хөтөлбөрийн хүрээнд "Ажилтны цайны газар" -р ажилтнуудаа эрүүл,шим тэжээлтэй, үнэ төлбөргүй хоолоор үйлчилдэг. 2024 онд бид ажилтны цайны газартаа нийт 2.1 тэрбум төгрөг зарцуулсан;  3. "Чингэлтэй дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо"-ны иргэдийн үйлдвэрлэсэн даавуун цүнхийг худалдан авч, шинэ ажилтны гарын бэлэг болгон өгөх үйл ажиллагааг 3 дахь жилдээ хэрэгжүүлж байна. Тус арга хэмжээнд 4,5 сая төгрөг зарцуулав.</p>
13. Тогтвортой өртгийн сүлжээний менежмент	13.1 Худалдан авалтын бодлого, журам	13.1.1 Дотоодын худалдан авалт болон тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн эрсдэл боломжыг хангасан худалдан авалтын бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм/Үгүй	<p><b>Тийм.</b> Одоогоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа "Худалдан авалтын журам"-н дагуу бид дараах шаардлагуудыг харгалзан үздэг.</p> <p>2.5.1.1Нийгэм, байгаль орчин, ХЭМАБ-ын тогтолцоо хэрэгжүүлсэн эсэх;  2.5.1.2Бараа материал нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлдэггүй гэдгийг нотлох сертификат болон бичиг баримттай эсэх;  Сонгон шалгаруулалтын журмын  2.2.1Оролцогч нь байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл явуулж, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагуудыг бүрэн хангасан байх;  2.2.2НҮБ-аас батлан гаргасан Тогтвортой хөгжлийн 17-н зорилгыг ойлгодог, дэмжиж ажилладаг байх;  2.2.3Химийн хортой аюултай бодисын тухай Монгол Улсын болон Олон улсын хууль дүрэм журмыг хэрэгжүүлдэг байх; гэж тус тус заасан.</p> <p>Мөн 2024 онд "Гэрээт гүйцэтгэгч, ханган нийлүүлэгчийн удирдлагын журам"-г боловсруулсан бөгөөд энэхүү журмаар хамтран ажиллах гэрээт байгууллагуудад тогтвортой хөгжлийн тавигдах шаардлагыг багтаасан байдаг.</p>
	13.2 Дотоодын худалдан авалт	13.2.1 Дотоодын ханган нийлүүлэгчдээс авсан худалдан авалтын хувь	%	Нийт худалдан авалтын <b>62.9%</b> -ийг дотоодын ханган нийлүүлэгчид эзэлж байна.
	13.3 Тогтвортой, ногоон худалдан авалт	13.3.1 Нийт ханган нийлүүлэгчдийн тоонд тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн шалгуураар сонгогдсон ханган нийлүүлэгчдийн хувь	%	Тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн шалгуураар сонгогдсон ханган нийлүүлэгчийн эзлэх хувь: <b>80%</b>
<b>4. Засаглалын шалгуур үзүүлэлтүүд</b>				
14. Авлига болон ёс зүй	14.1 Авлига, хээл хахуулийн эсрэг бодлого журам	14.1.1 Авлигын эсрэг эсвэл ёс зүйн бодлого, журам бий юу?	Тийм/Үгүй	<p><b>Тийм.</b></p> <p>*ТУЗ-өөс 2022 оны 8 сард "Ёс зүйн код" /Д-ТХХ-01-02/-ыг шинэчлэн баталсан.  *Ёс зүйн кодын хэрэгжилтийг хангаж ажиллахаар мэдээллийг хүртээмжтэй найдвартай сувгаар дамжуулан хүлээн авч, нууцлалыг хангаж ажиллах зарчмаар "Шүгэл үлээх систем" бусад холбогдох эх сурвалжийг ажилтнууд болон оролцогч талуудад нээлттэй байхаар 2022 онд ашиглалтад оруулав.  **"Шүгэл үлээх тогтолцооны үйл ажиллагааны журам", "Ёс зүйн кодын хэрэгжилтийг зохицуулах журам" гэсэн холбогдох журмуудыг боловсруулан батлуулж журмын дагуу хэрэгжилтийг ханган ажиллаж байна."</p> <p>Гэрээ, хэлцэл бүр авлига, ашиг сонирхлын эсрэг заалт, мэдээлэл хүлээн авах эх сурвалжийг заадаг. Одоогоор бүртгэгдсэн мэдээлэл байхгүй байна.</p>
	14.2 Үйл ажиллагаатай холбоотой авилгын талаарх үнэлгээ	14.2.1 Компанийн үйл ажиллагаанд нөлөөлсөн авлигатай холбоотой эрсдлүүдийг тодорхойлсон уу?	Тийм/Үгүй	<p><b>Тийм.</b></p> <p>Компанийн эрх бүхий албан тушаалтны хувийн ашиг сонирхлоос үүдэн авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг тодорхойлон дараах арга хэмжээг авч ажилласан:  -Нийт ажилтнуудад "Ёс зүйн код" болон холбогдох журмуудын танилцуулга сургалт оров /2023.10.30-2023.11.18/;  -2022-2023 оны "Шүгэл үлээх систем"-ийн хэрэгжилтийн тайлан танилцуулга 5 үйлдвэрийн ажилтнуудад оров /2024.03.26-2024.04.03/  2024 оны жилийн эцсийн эрсдэлийн мониторингийн үнэлгээгээр тухайн эрсдэл нь 10 буюу Дунд түвшинд байна</p>
15.1 Удирдах зөвлөлийн хараат бус байдал	15.1.1 Төлөөлөн удирдах зөвлөлд хараат бус гишүүдийн эзлэх суудлын хувь	%	<p>ТУЗ-д хараат бус гишүүдийн эзлэх хувь: <b>44.44%</b></p> <p>Төлөөлөн удирдах зөвлөлийн нийт 9 гишүүний 4 гишүүн нь хараат бус гишүүд байдаг. Хараат бус гишүүд нь дараах үндсэн үүргийг хэрэгжүүлэн ажилладаг. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлсөн эсэх, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн эсэхэд хяналт тавих, зөрчлөөс урьдчилан сэргийлэх;</li> <li>- Зөрчил илэрвэл уг зөрчлийг арилгахыг холбогдох этгээдээс шаардах, шаардлагыг эс биелүүлвэл уг асуудлыг ТУЗ-д тавьж шийдвэрлүүлэх, улмаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах шаардлагыг хүргүүлэх;</li> <li>- Компанийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагаас шаардах, хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах;</li> <li>- Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож, ТУЗ-ийн шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ талаар мэдээллэж, хувьцаа эзэмшигчдийн асуултанд хариулах, тодруулга хийх;</li> <li>- Гүйцэтгэх удирдлага, компани, хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчилдөх эрсдэлийг удирдаж, хяналт тавих;</li> <li>- Жилд нэг удаа хараат бус гишүүдээрээ тусдаа хуралдан ТУЗ болон компанийн үйл ажиллагааны талаар хараат бусаар хэлэлцэж, ирэх жилийн хувьд анхаарч ажиллах чиглэлээ тодорхойлох.</li> </ul>	

15. Компанийн засаглал	15.2 Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх	15.2.1 Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах дүрэм, журам бий юу?	Тийм/Үгүй	Тийм. ТУЗ-өөс 2021 онд баталсан "Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам" мөн 2022 онд шинэчлэн баталсан "Олон нийтэд хүргэх мэдээллийн журам" байдаг. Мөн 2023 онд "Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр"-ийг баталж тус хөтөлбөрийн хүрээнд ТУЗ-ийн ажлын албанаас хувьцаа эзэмшигч нарт зориулан гарын авлагыг бэлтгэн хүргэж, жилд 2-оос доошгүй удаа хувьцаа эзэмшигч нарын үйлдвэртэй танилцах аяллыг зохион байгуулж компанийн үйл ажиллагаанд оролцох оролцоог нь хангадаг. Манай компани хувьцаа эзэмшигч нарт хүргэх мэдээллийг монгол болон англи хэл дээр цаг тухай бүрт хүргэн, ил тод байдлын хэрэгжилтийг ханган дотоод болон гадаадын хөрөнгө оруулагч нарын эрх ашгийг ханган ажиллахаас гадна санал хүсэлтийг нь компанийн цахим хуудас, и-мэйл, утас зэрэг сувгуудаар дамжуулан хүлээн авч шуурхай хариу өгөн шийдвэрлэн ажилладаг.
	15.3 Компанийн засаглалын бодлого, журам	15.3.1 Компанийн засаглалын бодлого, журам бий юу?	Тийм/Үгүй	Тийм. ТУЗ-өөс 2022 онд "Компанийн засаглалын бодлого" болон "Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөр"-ийг баталсан. Тус хөтөлбөрийн хүрээнд засаглалын бодлого дүрэм журмуудаа шат дараатай шинэчлэн баталж, мөрдөн ажиллаж байна. Мөн засаглалын түвшинд байвал зөвхөн бодлого, дүрэм журмуудыг нэгтгэсэн "Компанийн засаглалын дүрэм журмуудын эмхэтгэл"-ийг ТУЗ-ийн ажлын албанаас бэлтгэн, агуулгыг нь тогтмол шинэчлэн ажилладаг. Энэхүү батлагдсан бодлого, дүрэм журмыг компанийн хэмжээнд хэрэгжүүлэн ажиллахаас гадна, ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороод чиг үүргийнхээ дагуу тогтмол хуралдаж, шийдвэр гарган хяналт тавьж ажилладаг.
16. Комплаенс	16.1 Комплаенсын бодлого	16.1.1 Комплаенсын бодлого, журам бий юу?	Тийм/Үгүй	Тийм. ТУЗ-ийн №40 дугаартай 2024.10.30-ны өдрийн тогтоолоор "Комплаенсын бодлого"-ын баримт бичгийг шинэчлэн батлуулсан. <a href="https://info.gobi.mn/policy">https://info.gobi.mn/policy</a>
	16.2 Комплаенсын хөтөлбөр	16.2.1 Комплаенсын хөтөлбөр, журам (ажилтны сургалт, аудит, хяналтын систем, зөрчлийн талаар мэдээллэх, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх удирдамж, хориг гэх мэт) бий юу?	Тийм/Үгүй	Тийм. Хууль эрх зүй, ажилтны ёс зүй, шударга өрсөлдөөн гэх мэт хүрээнд үүсэж болох эрсдэлүүдийг тооцон урьдчилан сэргийлэх, зохицуулах зорилго бүхий "Комплаенсын үйл ажиллагааны журам" боловсруулагдаж байгаа бөгөөд уг баримт бичигт хяналтын систем, зөрчлийн мэдээлэл зэргийг тусгаж байгаа. "Говь ХК-ийн Нийцлийн газрын ажилтнуудад "Комплаенсын ойлголт", "Эрсдэлийн ойлголт" гэсэн сэдвүүдээр сургалт авч комплаенсын талаарх нэгдсэн ойлголт мэдлэг хүргэв.
17. Эрсдэлийн удирдлага	17.1 Эрсдэлийн удирдлагын бодлого	Эрсдэлийн удирдлагын бодлого, журам бий юу?	Тийм/Үгүй	ТУЗ-ийн №04 дугаартай 2023.02.03-ны өдрийн тогтоолоор Говь ХК-ийн "Эрсдэлийн удирдлагын бодлого"-ыг шинэчлэн баталсан.
	17.2 Эрсдэлийн хөтөлбөр	Эрсдэлийн хөтөлбөр, журам (ажилтны сургалт, дүн шинжилгээ, аудит, тайлан, эрсдлээс сэргийлэх удирдамж г/м) бий юу?	Тийм/Үгүй	Тийм. Гүйцэтгэх захирлын 2023.05.15-ны өдрийн А/245 тоот тушаалаар Говь ХК-ийн "Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам"-ыг баталсан. Байгууллагын эрсдэлийн удирдлагыг оновчтой, үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгын хүрээнд эрсдэлийн календарийн дагуу нийт газар, нэгжүүд хагас жил тутамд эрсдэлийн үнэлгээ болон эрсдэлийн мониторингийг хийж, гүйцэтгэлд Эрсдэлийн удирдлагын баг хяналт тавин ажиллаж байна. Хагас жил тутмын эрсдэлийн удирдлагын тайланг Эрсдэл аудитын хороонд тайлагнадаг.
18. Чанарын удирдлагын тогтолцоо	18.1 Чанарын удирдлагын бодлого	Чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх бодлого, журам бий юу?	Тийм/Үгүй	Тийм. 1. 2024 оны 5-р сарын 02-ны өдөр "Нэгдсэн удирдлагын тогтолцооны бодлого"-ыг баталсан /Б_ТХХ_19_01/. /Бодлогын хамрах хүрээнд Чанарын бодлого хамаарах бөгөөд дизайн хөгжүүлэлтийн хүрээнд, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хүрээнд, борлуулалт үйлчилгээний хүрээнд зорилт дэвшүүлэн ажиллаж байна. 2. Нэгдсэн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэхтэй холбоотой нийт 7 журам, бүтээгдэхүүний чанартай холбоотой нийт 16 журмыг батлан хэрэгжилтийг хангуулан ажилладаг. 3. Бүтээгдэхүүн хөгжүүлэлт, үйлдвэрийн чанарын технологи, бүтээгдэхүүний үл тохирлыг залруулах гэх мэт чанартай холбоотой бүхий л үйл ажиллагааг батлагдсан журмын дагуу хэрэгжүүлж байна. 4. Нэгдсэн удирдлагын тогтолцооны талаарх мэдлэг ойлголтыг "Шинэ ажилтны сургалт"-аар 7 хоногт 1 удаа, нийт ажилтнуудад баримт бичиг хариуцагч нараар дамжуулан улирал бүр ордог.
	18.2 Чанарын удирдлагын хөтөлбөр	Чанарын удирдлагын хөтөлбөр, журам (ажилтны сургалт, дүн шинжилгээ, аудит, тайлан г/м) бий юу?	Тийм/Үгүй	Тийм. 2024 онд Чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг 100% хангасан. Үүнд: - ISO 9001:2015 стандартыг магадлан аудитаар баталгаажуулах - Байгууллагын төлөв байдлыг тодорхойлох - Сонирхогч талуудыг тодорхойлох - Төлөвлөлт/ дэмжих үйл ажиллагааг сайжруулах - Дотоод аудит явуулах - Удирдлагын дүн шинжилгээ зохион байгуулах - Үл тохирол, залруулах арга хэмжээний төлөвлөлтийн гүйцэтгэлийг хангуулах Түүнчлэн 2024 онд байгууллагын 2 ажилтан Чанарын тогтолцооны менежерийн 40 цагийн сургалт, 9 ажилтан Менежментийн тогтолцооны дотоод аудиторын 16 цагийн сургалтад хамрагдан, гэрчилгээ гардан авав.
5. Салбарын нэмэлт шалгуур үзүүлэлтүүд				
19. Санхүүгийн үйлчилгээ	19.1 Санхүүгийн хүртээмж	19.1.1 Санхүүгийн мэдлэг дээшлүүлэх болон санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах санаачилга, арга хэмжээнд оролцсон хүмүүсийн тоо (улирал, жилээр)	хүн	Тайлант онд Санхүүгийн мэдлэг дээшлүүлэх чиглэлээр сургалт, хөтөлбөр хийгдээгүй.
		19.1.2 Банк, хувийн даатгалын үйлчилгээ болон АТМ-ын хүртээмж		Нийт ажилтнуудаа сайн дурын ЭМД-д өөрөө 50%-ийн хөнгөлөлттэй үнээр, 2 хүртэлх хүүхдээ үнэгүй даатгуулах боломжоор хангаж, 675 хүн хамрагдсан. Ажил олгогчийн хариуцлагын даатгалын хүрээнд хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилтнуудаа бүрэн хамруулдаг. Мөн хөдөө орон нутаг болон гадаадад томилолтоор явж буй ажилтнуудыг компанийн зүгээс гэнэтийн ослын даатгалд хамруулдаг. Компани дотор 2 АТМ болон Хаан банкны 1 салбар байдаг.
	19.2 Тогтвортой санхүүжилт	19.3.1 Нийт зээлийн багцад эзлэх ногоон /ТХЗ таксономийн ангилалд нийцсэн ногоон/ тогтвортой зээлийн эзлэх хувь	%	0%
20. Хөдөө аж ахуй	20.1 Тогтвортой бэлчээрийн талбай	20.1.1 MNS 6891:2020, Хариуцлагатай нүүдэлчин стандарт эсвэл түүнтэй ижил төстэй тогтвортой бэлчээрийн стандартыг хэрэгжүүлж чадсан бэлчээрийн талбайн хувь	%	Тогтвортой ноолуур, гурван талт хамтарсан төслийн хүрээнд сумуудын бэлчээрийн тогтвортой байдлыг дээшлүүлэх, малын эрүүл мэндийг сайжруулах, ямааны тоо толгойноос илүү нэг ямаанаас гарах гарцын үнэлгээг сайжруулах мөн мэдээллийн сан үүсгэхэд анхаарч ажиллаж байна. Тус төсөл дээр үндэслэн 2024 онд АХБ-ны санхүүжилтээр "Бэлчээрийн менежментийн төсөл"-ийг хэрэгжүүлэхээр хамтын ажиллагааг эхлүүлэв.
	20.2 Тогтвортой мал аж ахуй	20.2.1 MNS 6891:2020, Хариуцлагатай нүүдэлчин стандарт эсвэл түүнтэй ижил төстэй тогтвортой бэлчээрийн стандартыг нэвтрүүлсэн малын тоо	Тоо	Дээрх төслүүдийн хүрээнд Банхонгор аймаг Жинст сум, Хөвсгөл аймаг Их-Уул сумуудын нийт 106 малчин өрх хамарч байгаа бөгөөд "Бэлчээрийн менежмент" төслөөр хамрагдах сум, айл өрхийн хэмжээг нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байна.
21. Үйлдвэрлэл	21.1 Тогтвортой аргаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн	21.1.1 Текстилийн тогтвортой үйлдвэрлэлийн стандартын (MNS 6926:2021) дагуу үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо, эзлэх хувь	Тоо / %	MNS 6926 стандартыг 2022 оны 11-р сард 3 жилийн хугацаатайгаар баталгаажуулсан бөгөөд 2024 онд бид нийт 1,005,128 ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлэв.
	21.2 Буцаан татан авсан бараа бүтээгдэхүүн	21.2.1 Чанарын шаардлага, аюулгүй байдлыг хангаагүй буцаагдсан эсвэл худалдах боломжгүй болсон бүтээгдэхүүний хувь	Тоо	2024 оны нийт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо ширхэг: 1,005,128 ш, Үүнд: Сүлжмэл бүтээгдэхүүн: 652,708,000 ш Оёмол бүтээгдэхүүн: 29,499 ш Нэхмэл бүтээгдэхүүн: 322,921 ш  Бэлэн бүтээгдэхүүний дахин хийлт, зэрэг бууралтыг нийт үйлдвэрлэлийг 0.2%-с ихгүй байх зорилт тавин ажилладаг бөгөөд энэ онд 0.1%-н гүйцэтгэлтэй байна.
	21.3 Химийн бодисын менежмент	21.3.1 Химийн бодис болон хортой материалыг зохистой хадгалах бодлого, журам	Тийм/Үгүй	Тийм. 2023.12.04 өдөр батлагдсан "Химийн хортой болон аюултай бодис захиалах, худалдан авах, тээвэрлэх, хадгалах, ашиглах, устгах журам" хэрэгжиж байна.
	21.4 Устгалын бодис	21.4.1 Устгалын бодис ашиглах бодлого журам бий юу?	Тийм/Үгүй	
	21.5 Дахин боловсруулсан материал	21.5.1 Дахин боловсруулсан материал, орц ашиглалтын хувь	%	Нийт худалдан авалт дахь дахин боловсруулсан материалын худалдан авалтын эзлэх хувь: 8.5%  2024 онд бид 3,461,039,729.17 ₮-ийн дахин боловсруулсан бүтээгдэхүүний гэрчилгээ /GRS, FSC г.м/ бүхий туслах материал, бараа бүтээгдэхүүнийг худалдан авсан.

	21.6 Ногоон шошго, гэрчилгээжүүлэлт	21.6.1 Ногоон шошготой бүтээгдэхүүний эзлэх хувь ОУ-ын гэрчилгээ авсан байдал	%	<p>"1. Швейцарь улсын Цюрих хотод төвтэй OEKO-TEX байгууллагын "STANDARD 100 by OEKO-TEX" стандартын шаардлагыг ханган, 2024 оны 2-р сард Монголд анх удаагаа бэлэн бүтээгдэхүүн дээрх гэрчилгээг гардан авсан. Гэрчилгээтэй бэлэн бүтээгдэхүүн нь нэхмэл цамц, оймс, бээлий, малгай болон ороолт байгаа бөгөөд бид гэрчилгээний хамрах хүрээг тэлэхээр ажиллаж байна.</p> <p>2. Түүнчлэн, "STANDARD 100 by OEKO-TEX" гэрчилгээг 2024 оны 7-р сард 5 дахь жилдээ Ээрмэл утсан дээр авсан.</p> <p>2. Англи улсад төвтэй "Тогтвортой ноос ноолуурын эвсэл" / SFA байгууллагын "Цэвэр ноолуур боловсруулах зохистой дадал"-ын тохирлын үнэлгээнд 4 дахь удаагаа амжилттай хамрагдаж "Алтан батламжлал" гардан авсан.</p> <p>3. Ямааны ноолууран "Н-1, 02, 03, 57, 1000 кодтой утас нь химийн будаггүй, цайруулалтгүй ба эдгээр утсаар хийгдсэн сүлжмэл, нэхмэл, оёмол бэлэн бүтээгдэхүүн нь үйлдвэрлэлийн менежмент, чанарын үзүүлэлтүүд органик хөдөө аж ахуй гаралтай бүтээгдэхүүнд тавигдах шаардлагыг ханган "Органик бүтээгдэхүүн" гэрчилгээтэй.</p> <p>4. ISO 9001:2015 Чанарын удирдлагын тогтолцооны стандартын баталгаажуулалт авсан бөгөөд үүнтэй холбогдуулан бүтээгдэхүүний чанар өсч, гологдол болон дахин хийлтийн хувь багассан."</p>
22. Аж үйлдвэр	22.1 Нөхөн сэргээлт	22.1.1 Нийт ашиглалтын зориулалттай газартай харьцуулахад нөхөн сэргээлт хийсэн газрын талбайн хувь	%	<p>Говь ХК-ийн эзэмшлийн талбай нийт 49883м.кв талбайгаас 6546м.кв талбайд ногоон байгууламж эзэлдэг бөгөөд жил бүр нөхөн тарилт хийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэн ажилладаг.</p> <p>2024 онд нийт талбайд эзлэх ногоон байгууламжийн хэмжээ 13.1%-д хүргэсэн.</p>
	22.2 Торгууль	22.2.1 Байгаль орчны зөвшөөрөл, стандарт, дүрэм журмыг дагаж мөрдөөгүйгээс гарсан зөрчлийн тоо	Зөрчлийн тоо	<p><b>Байхгүй.</b> Бид дотооддоо Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй байгаль орчны хуулиуд болон стандартуудын нийцлийг жил бүр үнэлдэг бөгөөд 2024 оны хуулийн нийцлийн үнэлгээгээр 97.3%-н гүйцэтгэлтэй байна.</p>
23. Инновац	23.1 Дэвшилтэт техник, технологи	24.1.1 Байгаль орчин, нийгэм, эдийн засагт ээлтэй техник, технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, ашигласан уу?	Тийм/Үгүй	<p><b>Тийм.</b> 2024 оны 10-р сард Монголд анх удаа Conveyor Belt буюу дамжлагын системийн сүлжмэлийн үйлдвэрт нэвтрүүлж, ашиглалтад оруулсан. Энэхүү системийг нэвтрүүлснээр үйлдвэрлэлийн ажлын урсгал автоматжиж, гар ажиллагааг багасган, ажлын гүйцэтгэлийн хяналт, үнэлгээний процессыг улам сайжруулах боломжийг бүрдүүлж байгаа бөгөөд компанийн үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлж, чанар, хурдыг илүү өндөр түвшинд хүргэх боломж бүрдэнэ.</p>
		24.1.2 Бүтээгдэхүүний инновацийг дэмжсэн судалгаа, шинжилгээ, хөгжүүлэлтийн бодлого журам байдаг уу?	Тийм/Үгүй	<p><b>Тийм.</b> Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн журамд "Бүтээгдэхүүний инновац, судалгаа хийх" тухай тусгагдсан байдаг бөгөөд үүний дагуу хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.</p>

**БОНЗ-ын тайланг хянасан:**

Тогтвортой хөгжлийн хэлтсийн дарга

 Э.Ариунзул

**БОНЗ-ын тайланг боловсруулсан:**

Тогтвортой хөгжлийн хэлтсийн ахлах менежер

 О.Жаргалмаа